



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 33/13716508

Улаанбаатар хот

НТГАС - 2025/155/НА-СТА-Тулз

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлэх тухай" А/506 дугаар тушаалаар хүлээн авсан 5876 УНЛ улсын дугаартай тээврийн хэрэгслийн эзэмшлийн нэр солиулаагүй үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Тээврийн хэрэгслийг өөрийн өмчлөлд шилжүүлж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Зоонозын өвчин судлалыг төвийн дарга М. Мөнгөнцэцэг, нягтлан бодогч Р. Саранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК ЗАХИРАЛ

Д. ТОВУУДОРЖ

ХЯНАСАН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР

